



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/325

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.4, 4.1 дэх заалт, аймгийн ИТХ-ын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнд орсон өөрчлөлт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомж, түүнд орсон өөрчлөлтийг хэрэгжүүлэх онол арга зүйн мэдлэгийг албан хаагчдад эзэмшүүлэх, дээрх хууль тогтоомжийг сайтар хэрэгжүүлж буй бусад аймаг, нийслэлийн байгууллагуудын арга туршлагыг судалж, дэвшилтэд арга ажиллагааг орон нутагтаа нэвтрүүлэх бүсийн сургалт, зөвлөгөөнийг байгуулахад зориулж аймгийн Орон нутгийн өмчийн газарт 5,000,000 (Таван сая) төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсүгэй.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай санхүүгийн дэмжлэг 5,000,000 (Таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнд орсон өөрчлөлт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх онол арга зүйн мэдлэгийг албан хаагчдад эзэмшүүлэх, дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй бусад аймаг, нийслэлийн байгууллагуудын арга туршлагыг судалж, дэвшилтэд арга ажиллагааг орон нутагтаа нэвтрүүлэх бүсийн сургалт, зөвлөгөөнийг үр дүнтэй зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР



d/zahiramj

6713010000